



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠑᠐᠑1 оны ᠐᠑ сарын ᠐᠑ өдөр

Дугаар А/331

Мандалговь

Ажлын хэсэг байгуулж, дэмжлэг
үзүүлэх тухай

Ахмад настны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 14 дүгээр зүйлийн 14.6, Ахмад настны талаар 2018-2021 онд баримтлах бодлогын 5.3, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2, 4, 3, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн ахмадын урлагийн 7 дугаар наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: А.Нарантуяа (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: М.Болор-эрдэнэ (Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Гишүүдэд: Н.Дэлгэрмаа (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Ц.Сугир (Аймгийн ахмадын хорооны дарга)

Х.Цогзолмаа (Боловсрол, соёл урлагийн газрын ахлах мэргэжилтэн)

Б.Цолмонгэрэл (Төв Халхын Дуулалт Жүжгийн Театрын менежер)

Б.Ундармаа (Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн ажилтан)


2. Аймгийн ахмадын урлагийн 7 дугаар наадмыг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Аймгийн ахмадын урлагийн 7 дугаар наадмын 1 дүгээр шатны шалгаруулалтыг 2021 оны 09 дугаар сарын 03-наас 07-ны өдрүүдэд удирдамжийн дагуу цахимаар, 2 дугаар шатны шалгаруулалтыг 09 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, үр дүнг 09 дугаар сарын 20-ны дотор багтаан тайлагнахыг ажлын хэсгийн дарга (А.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

4. Аймгийн ахмадын урлагийн 7 дугаар наадмыг зохион байгуулах зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

5. Аймгийн ахмадын урлагийн 7 дугаар наадамд зарцуулагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210945